



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар ХЗ-20/01

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11.9 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “Сайн” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар ХЗ-20/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг хавсралтын дагуу нийт 198,800,000.00 (нэг зуун ерэн найман сая найман зуун мянган) төгрөгөөр баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын 2020 оны 04 сарын 12 өдрийн
Хр-2020 дугаар тогтоолын хавсралт



“Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2020 оны зардлын төсөв

№	Зардлын төрөл	Зардлын дүн /мян.төг/
1	Цалин, урамшуулал	161,000.0
2	НДШ 12.5%	13,900.0
3	Бичиг хэрэг, хангамжийн зардал	1,500.0
4	Шатахуун	2,400.0
5	Томилолт, үйл ажиллагааны зардал	20,000.0
	НИЙТ	198,800.0



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар ХЗ-20/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг тус тус 2 жилийн хугацаатайгаар сонгосугай.

1.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1 Монгол Улсын иргэн Даваахүү овогтой Нарангэрэл
- 1.1.2 Монгол Улсын иргэн Даваасамба овогтой Дэлгэрмаа
- 1.1.3 Монгол Улсын иргэн Чулуунбаатар овогтой Дондогмаа
- 1.1.4 Монгол Улсын иргэн Сайнбаяр овогтой Мөнгөнцэцэг
- 1.1.5 Монгол Улсын иргэн Чулуун овогтой Ганхуяг
- 1.1.6 Монгол Улсын иргэн Гэрэлт овогтой Тэлмэн

1.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1 Монгол Улсын иргэн Мягмаржав овогтой Халиунбат
- 1.2.2 Монгол Улсын иргэн Дарамбазар овогтой Балдорж
- 1.2.3 Монгол Улсын иргэн Банзрагч овогтой Ганбаатар

ХУРЛЫН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ